



Б.САЙНБАЯР

“ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ” ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2025.06.30

Улаанбаатар хот

Захиалагч байгууллага	Зам, тээврийн яамны харьяа Монгол Улсын Далайн захиргаа
Хариуцах нэгж	Монгол Улсын Далайн захиргааны Хөлөг онгоц, усан замын бүртгэл хяналтын хэлтэс
Байршил	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, А.Амарын гудамж, Лагшан төв 9 давхар
Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	1.Монгол Улс Нэгдсэн Үндэстний байгууллагаас 2013 онд батлагдсан “Хуурай боомтын тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2016 онд нэгдэн орсон. Уг хэлэлцээрт нэгдэн орсонтой холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 34 дүгээр тэмдэглэлд Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Монгол Улсын Далайн захиргаанд эрхлэх асуудлын хүрээнд хэлэлцээрийг хэрэгжүүлж ажиллах үүргийг шилжүүлсэн. Хуурай боомт нь далайн боомтын үргэлжлэл бөгөөд далайн боомтын баримт бичиг хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр тусгаж өгч байгаа явдал юм. Иймд Далай ашиглах тухай хуулинд “хуурай боомт” гэсэн нэр томъёог тодорхойлох, мөн хуурай боомтын тухай хэлэлцээрийг хэрэгжүүлж ажиллах, Монгол Улсад хуурай боомт байгуулах үйл ажиллагааг Монгол Улсын Далайн захиргаа хариуцан ажиллах заалтыг нэмж тусгах. Мөн далайн тээвэр, далайн боомт, хуурай боомтын зарим зохицуулалтыг тусгах санал боловсруулах хэрэгцээ, шаардлага үүссэн. 2.Далай ашиглах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Хяналтын улсын байцаагч нь хөлөг онгоцны инженер мэргэжилтэй, далайн салбарын ажлын туршлагатай, холбогдох сургалтын хөтөлбөрт хамрагдаж мэргэшсэн, эрүүл чийрэг, бие бялдрын бэлтгэлтэй байх зэрэг ерөнхий шаардлагыг хангасан байна.” гэж заасан. Монгол Улс нь далайд гарцгүй 44 улсын нэг бөгөөд хөлөг онгоцны нээлттэй бүртгэлийн үйл ажиллагааг Улаанбаатар хотоос зохион байгуулж хэрэгжүүлдэг. Далайд гарцтай эргийн улсуудтай харьцуулахад хөлөг онгоц дээрхи хяналт шалгалтын үйл ажиллагааг өөрсдийн нөөц боломж бололцоод тааруулан харьцангуй цөөн явуулдаг. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй 240 гаруй хөлөг онгоц их далайд далайн

	тээврийн үйл ажиллагаа явуулдаг ба эдгээр хөлөг онгоцнуудад хяналт, шалгалт явуулах улсын байцаагчийн орон тоо, бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин, мэргэжилтэн Монгол Улсад төдийлэн элбэг байдаггүйгээс үүдэн Далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагчийг томилоход хүндрэлтэй байна. Монгол Улсаас бэлтгэгдсэн далайн салбарын инженер мэргэжилтэн нийт 10 гаруй байдаг. Эдгээр бэлтгэгдсэн мэргэжилтэй боловсон хүчин, мэргэжилтнүүдийн дийлэнхи хувь бусад орны их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлэхээр суралцаж, зарим хувь нь хувийн бизнес эрхлэн ажиллаж амьдарч байна. Иймд дээрх хүндрэлтэй нөхцөл байдлыг арилгах үүднээс холбогдох хуулийн зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна. 3.Зөрчлийн тухай хуулийн 14.14 дүгээр зүйлийн “1.16.хөлөг онгоцны аюулгүй байдал, түүний харуул, хамгаалалтын зохион байгуулалт хангалтгүй, аюулгүй ажиллагааны сургалт, дадлага хийгдээгүй, аюулгүй байдлыг хангах талаар тавигдах нийтлэг шаардлагыг зөрчсөний улмаас боомтын улсын хяналт, шалгалтаар саатуулагдсан тохиолдолд тухайн хөлөг онгоц эзэмшигчийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан байдаг. Энэхүү торгуулийн хэмжээний дүнг ам.долларт хөрвүүлэхэд 490-550 орчим ам.долларын торгуулийн дүн болох ба энэ нь тухайн зөрчил, дутагдал гаргасан хөлөг онгоц, түүний эзэмшигч, менежер компанид бага хэмжээний торгуульд тооцогдох ба бусад орны хөлөг онгоц бүртгэлийн байгууллага, Далайн захиргааны торгуулийн хэм, хэмжээний хувьд 10 дахин бага дүн байна. Иймд олон улсын жишиг үндэслэн Зөрчлийн тухай хуулийн торгуулийн хэм, хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагатай байна. 4.Бусад.
Ажлын даалгаврын нэр	“Далай ашиглах тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд авах зөвлөх үйлчилгээ
Ажлын зорилго	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.” гэж заасны дагуу Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахад энэхүү ажлын зорилго оршино.
Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил:	Зөвлөх үйлчилгээний, судалгааны ажлын хүрээнд дараах ажлын үр дүнг хүлээн авна: 1.Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа;

	2.Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулах; 3.Хууль тогтоомжийн тухай хууль болон үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төсөл боловсруулах; 4.Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслийг боловсруулах;
Арга зүй:	-Хууль тогтоомжийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт -Хуулийн төсөл боловсруулах болон судалгааны нийтлэг бусад арга зүйг ашиглах
Даалгаврын хугацаа:	Гэрээ байгуулсанаас хойш хуанлийн 30 хоног
Багийн бүтэц, бүрэлдэхүүн:	Зөвлөхөд тавигдах шаардлага: 1.Хуульч, эрх зүйч мэргэжилтэй, бакалавр ба түүнээс дээш цолтой байх 2.Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх 3.Хууль зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байх Шаардагдах баримт бичиг: 1.Зөвлөх багийн танилцуулга 2.Диплом 3.Иргэний үнэмлэхний хуулбар
Төлбөрийн нөхцөл:	Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох зардал, татвар багтсан байна.